



**“УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН” ОНӨТҮГ-ЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

**“УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН” ОНӨТҮГ-ЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 06 дугаар сарын 10

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (мян.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ. /НЗДҮАХ 2.6/							
1	Зорилт 1. Улаанбаатар хотын музейн барилгыг засварлаж үйл ажиллагааг боловсрол, түүх соёлын чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлнэ. /НЗДҮАХ-2.6.2.3/						
1.1	Музейн барилгыг түүхэн байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөлийн шинэ барилга барих санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ ажлын хүрээнд холбогдох бичиг баримтыг боловсруулна.	-	Хүргүүлсэн саналын тоо		1	Тайланд хугацаанд тус ажлын хүрээнд холбогдох албан бичиг төслийн саналыг холбогдох маягтын дагуу 3 албан бичгээр хүргүүлсэн байна. -Улаанбаатар хотын музей нь 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах төсөл, арга хэмжээний саналаа холбогдох шаардлагын маягтын дагуу боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 37 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. -Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 2026 онд шинээр хэрэгжүүлэх төслийн саналаа "Койка"-ийн төсөл боловсруулах загвар (PCP)-ын дагуу англи, монгол хэл дээр боловсруулан 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 83 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн. -"Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 85 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн. Эхлэсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100
Зорилт 2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт - Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ							

2.1	Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлнэ.	668,183.7 Нийслэлийн төсөв	Улирал бүр тайлан гаргаж хүргүүлэн тоо	1	1	<p>-2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар "ЗӨРЧИЛГҮЙ" санал дүгнэлт авч, Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст 02 сарын 25-ны өдөр хүргүүлэн нэгтгүүлсэн.</p> <p>-2024 оны хагас жилийн батлагдсан төсөв нийт 368,307.1 мянган төгрөг Үүнд: орон нутгийн төсвөөс 366,417.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,890.0 мянган төгрөг байна. Батлагдсан төсвийн гүйцэтгэл 332,725.3 мянган төгрөг. Үүнд: олгосон санхүүжилт 331,694.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 1,030.5 мянган төгрөг. Төсвийн урсгал зардал 236,805.3 мянган төгрөг байна.</p> <p>-2023 оны 12 сар, 2024 оны 01-05 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, орлогын болон өр авлагын мэдээг гарган нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж, хянуулж баталгаажуулсан.</p> <p>-Батлагдсан төсвийн зардлын бүлэг хоорондын зохицуулалт хийлгэх саналыг зохих журмын дагуу бэлтгэн захирлын 03 сарын 05-ны өдрийн 38, 05 сарын 29-ны өдрийн 88 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлж өр, авлагагүй ажилласан.</p> <p>-Ажилчдад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардал, түүх соёлын хадгалалт хамгаалалтын зардлын 1, 2-р улирлын санхүүжилтийг төрийн сангийн үйл ажиллагааны журмын хавсралт маягтын дагуу бэлтгэж нийслэлийн төрийн сангийн төсвийн ерөнхий нягтлан бодогчоор хянуулж, 03.11, 03.25, 05.24-ны өдөр нийт 3 удаа 18,799.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан Эхлэсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.03.31 Биелэлтийн хувь: 100%</p>	100 1
2.2	Байгууллагын эд хөрөнгийн хагас болон жилийн эцсийн тооллого хийлгүүлж, тооллогын үр дүнгээр		Баримтын тоо	2	1	<p>Тайлант хугацаанд сан хөмрөгийн тооллого 1 удаа хийгдсэн.</p> <p>-Сан хөмрөг хүлээлцэх тооллогыг музейн захирлын 2024 оны А/17 дугаар тушаалаар 2024</p>	100 2

	илүүдэлтэй, ашиглагдаагүй хөрөнгийн бүртгэлийн бэлтгэл ажлыг ханган, үр дүнг захиргааны зөвлөлд танилцуулах					оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд явуулав. Энэхүү тооллогоор 812 дэсийн 3502 үзмэр тоологдохоос 806 дэсийн 3495 ширхэг үзмэр тоологдож, 6 дэсийн 7 ширхэг үзмэрийг Соёлын Өвийн Төвд сэргээн засварлуулахаар явуулсан тул тооллогод хамрагдсангүй. Ажил хүлээлцсэн тооллогын илтгэх хуудсыг боловсруулан гаргаж, музейн удирдлагад танилцуулав. Эхлэсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	
2.3	Байгууллагад шинээр худалдаж авсан үндсэн хөрөнгө болон бараа материалыг дансны ангиллын дагуу хаягжуулах, коджуулах ажлыг зохион байгуулах- Нийт албан хаагчдад шаардлагатай бараа материалын захиалга авах,олголт, утас болон бусад үйлчилгээний хугацааг сунгах ажлыг хариуцах	-	Олгосон бараа материалын тоо	-	500	Музейн ажилтан албан хаагчдад шаардлагатай бичиг хэргийн данснаас бичгийн цаас болон бусад хэрэгсэлд өссөн дүнгээр 367 ширхэг 1,133.2 мянган төгрөг, цэвэрлэгээний болон аж ахуйн материал 161 ширхэг 3,128.6 мянган төгрөг, хангамжийн материалын данснаас 487 ширхэг 213.8 мянган төгрөг, бусад материалын данснаас 1129 ширхэг 3,744.0 мянган төгрөг, нийт 9,299.5 төгрөгийн материалыг цаг тухай бүрт нь олгож, бүртгэлийг дансдыг хөтөлсөн. Мөн байгууллагын утас, бусад үйлчилгээний эрх сунгах ажлыг хариуцан ажилласан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.03.31 Биелэлтийн хувь: 100%	100 3
2.4	Архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын ажлын зохион байгуулалтыг хууль тогтоомж, стандарт, журам зааврын дагуу хөтлөн явуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна	Зааврын дагуу хөтлөн явуулна	-Албан хэрэг хөтлөлтийн edoc системээр ашиглах журмын дагуу үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан. - Өссөн дүнгээр байгууллагад ирсэн бичиг нийт 96 байна. Судалж байгаа 6 албан бичиг байна. Хугацаа хоцорсон, шийдвэрлэгдээгүй болон буцаагдсан албан бичиг байхгүй. -Өссөн дүнгээр байгууллагаас нийт 91 албан бичиг явуулсан байна. Явсан бичгийн стандарт, боловсруулалтад хяналт тавьж, хэвлэмэл хуудсанд буулгаж, бүртгэж илгээж байна. Буцсан, зөрчилтэй бичиг байхгүй. -Байгууллагын захирлын А тушаал 21, Б тушаал 22 нийт 43 тушаалыг албан хэрэг хөтлөлтийн	100 4

					<p>стандартын дагуу боловсруулан, хэвлэмэл хуудсанд буулган, бүртгэл хөтөлж байна.</p> <p>-Ажилтан, албан хаагчдаас архивын баримт хүлээн авах хуваарь гарган албан хаагчдад мэдэгдэж, баримт хүлээн авч байна.</p> <p>Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн 01 хурлын тэмдэглэл хөтөлж, хянуулан албажуулав.</p> <p>-2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг албан хаагчдын саналын дагуу боловсруулан батлуулсан. Мөн албан хаагчдаас хуваарийн дагуу баримтуудыг хүлээн авсан.</p> <p>-2023 оны хүлээн авсан баримтуудыг байнга, түр, 70 жилээр ангилан төрөлжүүлэн, архивын стандартын дагуу төрөлжүүлж хадгаламжийн нэгж үүсгэн бүртгэл үйлдэн, архивд шилжүүлэв.</p> <p>-Захирамжлалын А тушаал 60, Б тушаал 21 цахим баримтыг актаар хүлээлгэн өгсөн.</p> <p>-Нийт 52 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийж, данс бүртгэл хөтөлж, архивын стандартын дагуу үдэж хавтаслав.</p> <p>-Харъяа Нийслэлийн архивд нөхөн баяжилтын 2014-2022 оны байнгын 191 хадагалмжийн нэгж, 1 дэсийн 236 ш гэрэл зургийг актаар хүлээлгэн өгсөн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>		
2.5	<p>Дээд газрын тогтоол, шийдвэрээс өөрийн байгууллагад холбогдох заалтыг хяналтад авч, бүртгэл хяналтын карт хөтлөх, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжүүлсэн мэдээ тайланг хагас жил, бүтэн жилээр гаргаж, үр дүнг байгууллагын удирдлагад танилцуулж холбогдох дээд байгууллагад илгээнэ.</p>	-	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт</p>	<p>Зааврын дагуу хөтлөн явуулна</p>	<p>Зааврын дагуу хөтлөн явуулна</p>	<p>Дээд байгууллагаас ирсэн хууль 2, тогтоол 2, НЗД-ын захирамж 4-ийг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Холбогдох тайланг дээд байгууллагад илгээсэн.</p> <p>1.Төсвийн тухай хууль, шилэн дансны болон холбогдох хуулийн хүрээнд: - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын тушаалаар баталсан журмын дагуу санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгыг иж бүрэн бэлтгэж байна.</p> <p>2.Шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж холбогдох тайланг сар бүр шилэн дансанд байршуулан ажиллаж байна.</p>	100 5

						<p>3.2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Дугаар 02 МУ-ын Засгийн газрын тогтоол – Бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаандаа тогтоолыг хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>4.2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Нийслэлийн засаг Даргын А/01 дүгээр захирамж 2024 оны “Тохижилт бүтээн байгуулалтын жил” болгон зарлах тухай: - 2024 оны төлөвлөгөөнд тусган ажиллахаар шийдвэрлэв.</p> <p>5.2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн НЗД-ын А/91 дугаар захирамж Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаах авах арга хэмжээний тухай – А/91 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, байгууллагад ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг хагас жилийн тайлан мэдээнд тусгаж, ЗДТГ-т илгээв.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	
2.6	Музейн ажилтнуудын ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан ажлын тоо	1	1	<p>2024 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө 2024 оны 1-р улирлын тайланг цахимаар google share программаар мэргэжилтэн бүрээс хүлээн авав.</p> <p>-Нийслэлийн Соёл урлагийн газрын 2024 оны үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө гаргаж НСУГ-т хүргүүлсэн.</p> <p>-2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг мэргэжилтэн тус бүрээс хүлээн авч нэгтгэв.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	100 6
2.7	Байгууллагын улирал, хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэн гаргаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж холбогдох байгуулагад хугацаанд нь хүргүүлнэ.	-	Нэгтгэн гаргах тайлангийн тоо	1	1	<p>-Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулахаар НЗДТГ-т хүргүүлсэн</p> <p>-Байгууллагын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөг ERP программын ажил төлөвлөлт цэст байршуулав.</p> <p>-Байгууллагын 2024 оны 1-р улирлын тайлан нэгтгэн гаргаж НЗДТГ, НСУГ-т хүргүүлэв.</p> <p>-Музейн 2023 оны үйл ажиллагааны статистик мэдээ, 1,2-р улирлын үйл ажиллагааны статистик</p>	100 7

						<p>дүн мэдээг тус тус нэгтгэн НСУГ-т ERP болон nsug.statistic@gmail.com хаягаар илгээлээ.</p> <p>-Байгууллагын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг НЗДТГ, НСУГ-т хугацаанд нь тус тус хүргүүлсэн.</p> <p>-Соёлын салбарын мэдээллийн нэгдсэн шинэ системд Улаанбаатар хотын музейн 2021-2023 оны статистик дүн мэдээг нэгтгэн орууллаа.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>	
2.8	<p>Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн харилцаа, байгууллагын бүтцийн нэгж бүрийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөө гаргаж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна.</p>	-	Дотоод хяналт шалгалт хийсэн тоо	1	1	<p>-Музейн дотоод хяналтын журам, дотоод хяналтын ажилтны албан тушаалын тодорхойлолтыг бусад музей болон соёлын яамны жишиг журамтай харьцуулан шинээр боловсруулж арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн музейн захирлын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/11 дугаар тушаалаар батлууллаа.</p> <p>-Музейн ажилтнуудын албан хэргийн цахим файлын хадгалалтад хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 2024 оны 02 дугаар сарын 28, 29-ний өдөр хяналт шалгалтад 11 ажилтан хамрагдсан ба комиссын гишүүдийн хяналтын хуудсанд өгсөн дундаж оноо 4.61 буюу 92.2%-ийн үнэлгээтэй гарсан.</p> <p>-Хяналт, шалгалт хийсэн ажлын тайланг 2024 оны 03 дугаар сарын 28-ны дотор Захирлын дэргэдэх Захиргааны зөвлөлд танилцуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг хууль, дүрэм, журмын хүрээнд авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>	100 8
2.9	<p>Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан батлуулж,</p>	(-6,000) Батлагдсан төсөв дотор	Боловсруулсан баримт бичгийн тоо	1	1	<p>-Дээд байгууллагаас зохион байгуулсан танхим, цахимын 5 нэр төрлийн сургалтад 9 албан хаагчдыг хамруулсан.</p> <p>- Музейн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Музейн албан хаагчдын мэдлэг боловсролыг хөгжүүлэх, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийж</p>	100 9

	хэрэгжилтийг зохион байгуулан, тайлагнана.					<p>хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулж мөрдөн ажиллаж байна.</p> <p>- Монголын Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбооноос зохион байгуулсан “Монголын Үндэсний музейг англи хэлээр тайлбарлах нь” сургалтад тайлбарлагч Д.Дэлгэрмөрөн, Соёлын өвийн төв, Монгол дахь соёлын өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны төсөлтэй хамтран зохион байгуулсан “Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх онол, практик хосолсон сургалт”-д Менежер Б.Нарангэрэл нар хамрагдаж нийт 100,000 төгрөгийн зардал гаргав.</p> <p>-Музейн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Б/14 дугаар тушаалаар албан хаагчдын ээлжийн амралтын хуваарь, амарсан албан хаагчдыг түр орлох хуваарь гарган батлуулж, мөрдөн ажиллаж байна.</p> <p>- Музейн захирлын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Б/10 дугаар тушаалаар ША Г.Очбаярт “Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд олгох мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу сүүлийн нэг жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгов.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	
2.10	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих.		Хэрэгжүүлсэн ажлын тоо	1	1	<p>“АРЧЛАХГҮЙ БОЛ УРГАХГҮЙ” уриан дор явагдсан 2024 оны хаврын мод тарилтад музейн ажилтан, албан хаагчид Баянгол цэцэрлэгт хүрээлэнд хайлаас модны 15 ширхэг суулгацыг /нэг бүрийн үнэ 9800 төгрөгөөр/ худалдан авч суулгах ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	100 10
2.11	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг		Хэрэгжүүлсэн ажлын тоо	-	1	<p>“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ-д музейн арга зүйч хүсэлт тавьсны дагуу 2024 оны 2 дугаар сарын 2-нд тус байгууллагын сургагч багш Ч.Ундрах, хуулийн зөвлөх Д.Санчир музейд хүрэлцэн ирж “Жендерийн тэгш байдал,</p>	100 11

	үүргийг ажиллах.	хэрэгжүүлж				ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамт, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” 3 цагийн сургалтыг музейн танхимд зохион байгууллаа. Сургалтад оролцсон ажилтнуудаас цаашид авах сургалтын санал мэдээллийн судалгаа авлаа. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	
2.12	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Хэрэгжүүлсэн ажлын тоо	-	1	-Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр музейн захирал батлав. -Монгол улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээний “Харилцан хүндэтгэе” нэг сарын аяныг зохион байгуулсан. Уг аянд нэгдэж, байгууллагын фэйсбүүк, инстаграмм, пэйж хаяг, мэдээллийн самбарт холбогдох мэдээллийг байршуулах нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэн тайланг НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст 03 дугаар сарын 24 өдрийн 49 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. -2024 оны 2 дугаар сарын 2-нд тус байгууллагын сургагч багш Ч.Ундрах, хуулийн зөвлөх Д.Санчир музейд хүрэлцэн ирж “Жендерийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамт, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” 3 цагийн сургалтыг музейн танхимд зохион байгууллаа. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100 12

Зорилт 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт – Музейн зорилго, үйл ажиллагааны чиглэл /НИТХ Тэргүүлэгчдийн тогтоол дугаар 32/

3.2	Музейн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын баталгаат орчин бүрдүүлж, үзмэрийг арчлан тордон, сэргээн засварлуулна. /УБХМД-4.2.2/	-	Хадгалалт, баталгаат орчин, сэргээн засварлуулсан үзмэрийн нийт дүнгийн	-	3%	Үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд нийт үзмэрийн 7 хувийг хадгалалтыг сайжруулан ажилласан байна. Эхэлсэн, дууссан огноо: 2023.06.07 Биелэлтийн хувь:100%	100 1
3.2.1	Музейн үзмэрийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах, эрсдлээс хамгаалах ажлыг зохион байгуулах	(-9,110) Батлагдсан төсөв дотор	Үзмэрийн тоо	-	40	-Нийт 43 дэсийн 268 ш биет үзмэр, гэрэл зургийн, хатаж хугарсаныг тэнийлгэн кальки цаасаар бүрж өмнөх болон дараах байдлын зургийг авч баримтжуулан өнгөтөөр хаяг хийж хэвлэн үзмэрийн бүрэлт калькины гадна талд нааж хайрцаг, сав баглаа боодол хийж хадгалав. -СӨҮТөвд 6 дэсийн 7 ширхэг үзмэрийг сэргээн засварлуулахаар хүлээлгэн өгсөн. -2023 онд СӨҮТөвд сэргээн засварлуулахаар хүлээлгэн өгсөн 1 дэсийн 2 ширхэг үзмэрийг "Сэргээн засварлалтын ажлын тайлан №СӨҮТ.2023.74, №СӨҮТ.2023.75"-ийн хамт хүлээн авав. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100 2
3.2.2	Музейн сан хөмрөгийн өрөө болон үзүүллэгийн танхимын орчин нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулна.		Хийгдэх ажил	1	1	-2024 оны музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтад шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалын зардлын судалгаа хийж 9,110,000 төгрөгний төсөв бүхий зардалыг музейн захирлаар батлуулав. -Музейн ариутгал халдваргүйжүүлэлт, хортон шавжийн устгалыг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр гэрээт байгууллага болох "ХанСудар" ХХК-аар хортон шавьж халдваргүйжүүлэлтийг 247,500 төгрөгөөр хийж гүйцэтгүүлэв. -Хугацаа нь дууссан 2 ширхэг галын хор цэнэглүүлэх, галын сарайнд дутуу байсан гал унтраах багаж болох хөрөө, сүх, хувин, царил,	100 3

						<p>жоотуу зэргийг 175,800 төгрөгөөр худалдан авав.</p> <p>-Нийт 423,300 төгрөгөөр орчин нөхцөлийг сайжруулах ажил хийгдсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2023.01.02-2024.06.07</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>	
3.2.3	Музейн барилга, сан хөмрөг, үзмэрийн аюулгүй байдал болон музейн үйл ажиллагааны явцад хөтлөгдөх бүртгэлүүдэд тогтмол хяналт тавина.	-	Хяналт тавьсан тоо	-	4	<p>Музейн үйл ажиллагааны явцад хөтлөгдөх бүртгэлүүд болох</p> <ul style="list-style-type: none"> - Сан хөмрөг болон үзүүлэгийн танхимын чийг дулаан хэмжсэн бүртгэл - Үзүүлэгийн танхимын үзмэрийн аюулгүй байдал, хоргоны лац бүртгэл - Сан хөмрөгийн өрөөнд орсон гарсан хүмүүсийн бүртгэл - Үзүүлэгийн танхим дахь үзмэрт цэвэрлэгээ хийсэн бүртгэлд хуваарийн дагуу хяналт хийж, баталгаажуулж ажиллав. <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>	100 4
3.2.4	Музейн үзмэрийг бүртгэн баримтжуулах зааврын дагуу музейн үзүүлэгийн танхимын үзмэрийн аюулгүй байдал, арчилгаа цэвэрлэгээ, орчны хэвийн байдлыг хангаж, тогтмол хяналт тавина.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	Зааврын дагуу хөтлөн явуулна	Зааврын дагуу хөтлөн явуулна	<p>-Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2012 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/355 тоот тушаалын хоёрдугаар хавсралт ББЗ Маягт 58-ын дагуу дагуу музейн үзүүлэгийн танхим дахь витриний лацыг ажлын 5 өдөр шалгаж тухайн өдрийн жижүүрт хүлээлгэн өгөхдөө бүртгэлээ нийт 126 удаа хөтөлсөн.</p> <p>-Музейн үзүүлэгийн танхимын дотор болон гаднах дулаан, чийгшлийг хэмжиж бүртгэлээ нийт 126 удаа хөтөлсөн. Мөн шаардлагатай тохиолдолд шилэнд ус хийж тавих, чийгшүүлэгч асаах зэрэг арга хэмжээг авсан.</p> <p>-Үзмэр болон танхимын цэвэрлэгээг хуваарийн 6 удаа хийж гүйцэтгэв.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07</p> <p>Биелэлтийн хувь: 100%</p>	100 5
3.3	Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ. /УБХМД-4.2.3/						

3.3.1	Бүртгэн баримтжуулах зааврын дагуу музейн сан хөмрөгөөс үзмэр, эд өлгийн зүйлийг гаргах, буцаах акт үйлдэн, хөдөлгөөнд оруулах ажлыг зохион байгуулна.	-	Журмын дагуу зөрчилгүй акт үйлдэх 100%	-	-	<p>Тайлант хугацаанд "Музей дотор үзмэр, эд өлгийн зүйл хүлээлцсэн акт"-ыг 3 (гурван) удаа, музейгээс гадагш "Үзмэр, эд өлгийн зүйлийг түр гаргах, буцаах акт"-ыг 1 (нэг) удаа нийт 4 (дөрвөн) удаа хөдөлгөөний акт үйлдэн үзмэр, эд өлгийн зүйлийг хөдөлгөөнд оруулахад хяналт тавин ажилласан байна. Үүнд:</p> <p>1. Музейн захирлын 2024 оны А/03 дугаар тушаалаар үзүүлэгийн танхимд шинээр хийлгэсэн витринд тавигдах үзмэрийг №МД.2024.01 акт үйлдэн 16 дэсийн 24 ширхэг үзмэрийг сан хөмрөгөөс музей рүү оруулав.</p> <p>2. Музейн захирлын 2024 оны А/09 дүгээр тушаалаар "Улаанбаатар 1924-1954 он" сэдэвт үзэсгэлэнд тавигдах 13 дэсийн 13 ширхэг үзмэрийг МД.2024.02 акт үйлдэн сан хөмрөгөөс музей рүү оруулав.</p> <p>3. Музейн захирлын 2024 оны А/21 дүгээр тушаалаар сан хөмрөгөөс үзүүлэгийн 1 дүгээр танхимд тавигдах 1 (нэг) үзмэр, музейн байнгын үзүүлэгийн танхимаас тусгаарлах өрөөнд 2 (хоёр) үзмэрийг зөөж оруулахад хяналт тавин ажилласан.</p> <p>4. Музейн захирлын 2024 оны А/06 дугаар тушаалаар 6 дэсийн 7 ширхэг үзмэрийг "Үзмэр, эд өлгийн зүйлийг түр гаргах, буцаах акт №ГБ-2024-01"-ийг үйлдэн СӨҮТөвд сэргээн засварлуулахаар явуулсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02 -2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	100 6
3.4	Музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзүүлэгийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохимжтойгоор	-	Үзэсгэлэ нгийн тоо Үзэгчийн тоо	-	2 1300	<p>-Нийт 4 үзэсгэлэн буюу музейн байранд сан сэдэвчилсэн үзэсгэлэн 1, явуулын гэрэл зургийн 3 үзэсгэлэн гаргаж, олон нийтийн хүртээл болгосон. Үүнд:</p> <p>-2024.02.29-нд "Музейн нээлттэй өдрүүд-2024" арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын захиргаа байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан "Улаанбаатар 1924-1954" сан хөмрөгийн сэдэвчилсэн үзэсгэлэнг гаргасан.</p>	100 7

	дэглэн нийтийн хүртээл болгоно. /УБХМД-4.2.4/					<p>-2024.05.04-12-ны хооронд Соёлын яамнаас "Монгол Гэр" арга хэмжээг Сүхбаатарын талбайд зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд зориулан гэрэл зурагчин Сүгияама Тэрүзогийн 1983-2004 оны хооронд буулгасан Улаанбаатар хотын гэрэл зургууд болон "Өөрчлөгдөж буй Улаанбаатар" гэсэн гэрэл зургийн үзэсгэлэнг гаргаж, 2024.05.08-нд уг үзэсгэлэнг үзэгчдэд тайлбарлан хүргэсэн.</p> <p>-2024 оны 05 дугаар сарын 31-нд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байрны нэг давхарт (Яармаг дахь Хангарди ордон) тус байгууллагын ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан үзэсгэлэнг дэглэсэн.</p> <p>-2024.06.03-нд Улаанбаатар театр дээр Сүгияама Тэрүзогийн 1983-2004 онд авсан гэрэл зургууд болон Оскар Мамены ертөнц: Монголчууд цам ба Майдар сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг дэглэсэн.</p> <p>-Нийт өссөн дүнгээр том хүн 5886, оюутан 3498, хүүхэд 5029, гадаад хүн 728, хөгжлийн бэрхшээлтэй 15708 нийт хүн үйчлүүлсэн байна. Жич:"Монгол гэр" хөтөлбөрөөр явуулын үзэсгэлэнг олон хүн үзэж сонирхов. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02 -2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	
3.4.1	Музейн байранд сан хөмрөгийн үзмэрийн сэдэвчилсэн болон түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой үзэсгэлэн гаргаж олны хүртээл болгоно.	(-2,000) Батлагдсан төсөв дотор	Үзэсгэлэн гаргасан тоо	-	1	<p>-Улаанбаатар хотын захиргаа байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан "Улаанбаатар 1924-1954 он" сан хөмрөгийн сэдэвчилсэн 1 үзэсгэлэнг дэглэж олны хүртээл болгов. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	100 8
3.4.2	Түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой явуулын үзэсгэлэнг зохион байгуулна.		Үзэсгэлэн гаргасан тоо	-	1	<p>Тайлант хугацаанд явуулын гэрэл зургийн 3 үзэсгэлэнг гаргаж, олон нийтийн хүртээл болгосон. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	100 9

3.4.3	Музейн үзүүлэгийн танхим болон явуулын үзэсгэлэнд гарч буй үзмэрийн хаяг тайлбарыг бичихдээ “Музейн хаяг тайлбар бичих журам”-ыг мөрдөн ажиллана.	-	Байрлуулсан хаяг тайлбарын тоо	-	8	- Улаанбаатар хотын захиргаа байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан "Улаанбаатар 1924-1954 он" сан хөмрөгийн сэдэвчилсэн үзэсгэлэнд гарсан үзмэр, гэрэл зургийн 27 хаяг тайлбарыг "Музейн хаяг тайлбар бичих журам"-ын дагуу байрлуулсан. -"Монгол гэр" арга хэмжээнд гаргасан "Өөрчлөгдөж буй Улаанбаатар" үзэсгэлэнгийн гэрэл зургийн 8 тайлбарыг монгол, англиар хэвлэн гаргасан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100 10
3.5	Музей судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулна. /УБХМД-4.2.5/	-	Санд бүртгэсэн баримтын хувь үзүүлэлт	-	100%	Улаанбаатар хотын түүх судлалын баримт, мэдээллийн сан байгуулж, дүрмийг боловсруулах ажил хийгдэж эхний шатны хяналт хийгдэж байна. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 60%	60 11
3.5.1	"Улаанбаатарын мэдээ" сонины 1955-1990 оны дугаараас Улаанбаатар хоттой холбогдох тогтоол, шийдвэр, түүнтэй холбогдох мэдээ, нийтлэлийг шүүн авч, цахим хэлбэрт шилжүүлэх, баримтын эмхэтгэл гаргах ажлыг зохион байгуулна. 2-р боть	(-9,300) Батлагдсан төсөв дотор	Хэвлүүлсэн номын тоо	-	100	2024.01.22-нд Улаанбаатарын мэдээ сонинд хэвлэгдсэн хотын түүхтэй холбогдох мэдээ, нийтлэлийг цахим хэлбэрт шилжүүлэх 24/01-1 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээг Пүрэвийн Жаргалантай байгуулж, энэхүү гэрээгээр тус сонинд хэвлэгдсэн 1955-1990 оны тогтоол, шийдвэрийг шивүүлж 1000 нүүр цахим баримт авахаар болов. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 10%	10 12
3.5.2	Нийслэлийн иргэдийн дурсамжийг сурвалжлан авах, хадгалах зорилго бүхий "Улаанбаатарын аман түүх" хөтөлбөр боловсруулан батлуулж, дурсамжийн санг баяжуулах ажлыг зохион байгуулна.		Батлуулсан баримт, дурсамжийн тоо	-	1 4	-“Улаанбаатарын аман түүх” хөтөлбөрийг боловсруулж дуусгасан бөгөөд мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө аван, III улиралд батлуулахаар ажиллаж байна. -Нийслэл хотод амьдарч байсан ахмад настай 4 иргэнээс тэдний дурсамжийг сурвалжлан авч, хадгалсан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 80%	80 13

3.5.3	Музейн үзмэрүүдэд тодорхойлолт бичиж, үзмэрийн түүхийн судалгааг хийнэ.	-	Судалгаа хийсэн дурсгалын тоо	-	10	604. Орос, монгол сургууль 606. Пандлин сүм 611. Хотын намын хороо байгуулагдсан нь 616. Хүрээний хашаа 628. Өнөөгийн Улаанбаатар 687. Халх нүүдэлчид 688. Хятад худалдаачны хашаа 751. Улаанбаатар хотын хятад ажилчдын клубийн бат илэрхийлэх 763. Цэдэнбалын залуу нас ваар 764. Х.Чойбалсан ваар гэсэн 10 үзмэрт тодорхойлолт бичин, үзмэрийн түүхийн судалгааг хийж, алдаатай мэдээллүүдийг засах саналыг бүртгэл мэдээллийг санчид хүлээлгэн өгсөн. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100 14
3.5.4	Музейн сан хөмрөгт буй монгол бичиг болон гадаад хэлээр бичигдсэн үзмэрүүдийг хөрвүүлж, орчуулна.	-	Хэвлүүлсэн судалгааны өгүүллийн тоо	-	6	119. Алтыг бодтой харьцуулсан бичиг, 122. Хэрлэн барс хотын чуулганы даргад өгсөн бичиг, 125. Богдын ордонд засвар хийлгэсэн данс 129. Шинжлэх ухааны хүрээлэнгийн "Шинэ толь" сэтгүүл 135. Усан хөөрөг худалдаж авсан данс 138. Пионер сэтгүүл гэсэн 6 үзмэрийг хөрвүүлж, орчуулсан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100 15
3.5.5	Богдын хүрээний түүхийг гэрэл зургаар тодруулах нь" сэдэвт судалгаа хийж эхэлнэ.		Судалгааны бичвэрийн хуудасны тоо	-	15	"Богдын хүрээний түүхийг гэрэл зургаар тодруулах нь" судалгааны хүрээнд 1874-1911 онд Их хүрээнд ирсэн 10 гаднын жуулчин, судлаачдын 210 гэрэл зургийг цуглуулах ажлыг хийж гүйцэтгэв. Тайлант хугацаанд судалгааны бичвэрийн 15 хуудсыг бичив Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100 16
3.6	Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах,	(-6,000)	Багц ажлын тоо	-	3	1."Бидний баатар хот" боловсролын ажил 2.Хотын түүхийн сэдэвт лекц 3.Хэлэлцүүлэг	100 17

	нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна. /УБХМД-4.2.6/	Батлагдсан төсөв дотор				4.Хотын тойрон аялал Эхэлсэн, дууссан огноо: 2023.01.01-2023.06.07 Биелэлтийн хувь:100%	
3.6.1	Иргэдийг соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг мэргэжилтнүүдтэй хамтран үе шаттайгаар зохион байгуулна.	-	Хамруулсан иргэдийн тоо	-	150	Соён гэрээрүүлэх төлөвлөгөөний дагуу 1."Бидний баатар хот" боловсролын ажил-2834 хүүхэд залуусд 2.Хотын түүхийн сэдэвт лекц-382 хүн 3.Хэлэлцүүлэг-1 удаа 4.Хотын тойрон аялал-234 хүн гэсэн 4 багц ажлыг зохион байгуулж нийт 3450 хүүхэд, залуус, иргэдийг хамруулж, 1 илтгэл хэлэлцүүлэгт оролцсон. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь:100%	100 18
3.6.2	Музейн боловсролын ажлын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	-	Хөтөлбөрийн тоо	-	4	-2024 оны 03-р сарын 01-07-ны өдрүүдэд Соёлын яамнаас орон даяар зохион байгуулсан "Музейн нээлттэй өдрүүд"-ийн хүрээнд "Музей үзэх соёлыг хэвшүүлцгээе" уриан дор "Миний төсөөллийн Улаанбаатар" "Улаанбаатар хотын түүх соёлын үл хөдлөх дурсгал" сэдэвт боловсролын хөтөлбөрүүдийг 10 удаагийн давтамжтайгаар нийт 100 хүүхэд 3 том хүнийг хамруулан зохион байгуулсан. -2024 оны 04-р сарын 09-ны өдөр "Их засаг лицей" ЕБС-ийн 6а ангийн 28 сурагчдад "Улаанбаатар хотын түүх соёлын үл хөдлөх дурсгал" сэдэвт леги эвлүүлэх боловсролын ажлыг зохион байгуулсан. - 2024 оны 05-р сарын Соёлын яамнаас зохион байгуулсан "Монгол гэр" үзэсгэлэнд Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал" /будад материал/, "Төсөөллөө бүтээе", "Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал" /лего/, "Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал" /баримал/ зэрэг боловсролын хөтөлбөрүүдийг 1599 хүүхэд, 80 том хүн, 547 оюутан, 67 гадаад хүн нийт 2293 хүнийг хамруулж ажилласан.	100 19

						<p>- 2024 оны 05-р сарын 17-нд олон улсын музейн өдрийг “Музейн боловсрол, судалгааны төлөө” уриан дор Улаанбаатар хотод байрлалтай музейнүүд Чойжин ламын сүм музейд зохион байгуулсан ба “Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал” сэдэвт боловсролын ажлын хүрээнд нийт 83 хүүхдийг хамруулж ажилласан.</p> <p>- 2024 оны 05-р сарын 18-нд олон улсын музейн өдрөөр “Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал” сэдэвт боловсролын ажилд музейгээр үйлчлүүлсэн 11 хүүхдийг хамруулж ажилласан.</p> <p>- 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Солонго” төвийн 5 том хүн, 20 хүүхдэд “Марчаахай” контент, “Төсөөллөө бүтээе” сэдэвт боловсролын ажлыг зохион байгуулсан.</p> <p>-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байрны нэг давхарт (Яармагдахь Хангарьд ордон) тус байгууллагын ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан үзэсгэлэн, боловсролын ажлыг 108 хүүхдэд</p> <p>–“Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” Сүхбаатарын талбайд Нийслэлийн Соёл Урлагийн газраас боловсролын хөтөлбөр явуулахад зориулан барьсан задгай гэрт Улаанбаатар хотын музейгээс боловсрол танин мэдэхүйн ажлыг 250 хүүхэд залуусд зохион байгуулав.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь:100%</p>	
3.6.3	Иргэдийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд хотын түүхийн сэдэвт лекц зохион байгуулж, тойрон аялал хийж, хэлэлцүүлэгт оролцоно.	-	Хамруулсан иргэдийн тоо	-	110	<p>Тайлант хугацаанд 5 сэдвээр 8 удаа лекц, хичээл орж, 382 хүнийг хамруулав.</p> <p>Лекц:</p> <p>-Гайд сургалтын төвийн хөтөчийн сургалтад “Бид ямар түүхтэй хотод амьдардаг вэ” лекц хичээлийг 4 удаа орж, нийт 195 хөтөч хамруулав.</p>	100 20

					<p>-Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 47 албан хаагчдад “Улаанбаатар хот ба Чингэлтэй дүүргийн түүхийн тойм” сэдвээр лекц уншив.</p> <p>- Open Data Day буюу Өгөгдлийн нээлттэй өдөрт зориулсан MapAbility хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 40 залууст “Бидний хотын түүх” сэдвээр лекц уншив.</p> <p>-TEDxUlaanbaatar арга хэмжээнд илтгэгчээр оролцож, “Драмын театрын барилга: Түүх, архитектур” сэдэвт илтгэл тавив. Уг арга хэмжээнд 82 хүн оролцов.</p> <p>- 2024.05.22-нд МУИС-ийн улс төрийн ангийн 18 докторантад “Бид ямар түүхтэй хотод амьдардаг вэ?” лекц уншив.</p> <p>Хэлэлцүүлэг: 2024.03.24-нд Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооноос “ULAANBAATAR PHOTO WEEK-2024” арга хэмжээний хүрээнд зохион байгуулж буй “Түүхэн гэрэл зургийн ач холбогдол, үнэ цэн” эрдэм шинжилгээний бага хуралд оролцож, “Улаанбаатар хотын орон зайн өөрчлөлтийг гэрэл зургаар тодруулах нь ” (Барилгачдын талбайн жишээн дээр) сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлэв.</p> <p>Гайд хөтөч: Тайлант хугацаанд 5 аялалд 234 хүн хамруулав. 2024.02.05-нд ШУТИС-ийн Барилга архитектурын сургуулийн 34 оюутанд Гандантэгчинлэн хийдийн түүх, уламжлал, архитектурын талаар тайлбар хийж, Гандангийн дэнжид хадгалагдан үлдсэн гудамж, хашаа, гэр, байшинг танилцуулах явган аяллыг зохион байгуулав.</p> <p>- 2024.03.16-нд Гайд төвийн 70 суралцагчдыг Бага тойруугийн дурсгалт газруудаар явган аялалд хамруулж, хөтөчөөр ажиллав.</p> <p>- 2024.03.23-нд Гайд центр төвийн сургалтад хамрагдаж буй 14 гайдад “Улаанбаатар хоттой</p>
--	--	--	--	--	---

						<p>танилцах автобустай аялал"-д хамруулж, хөтөчөөр ажиллав.</p> <p>- 2024.04.13-нд Гайд сургалтын төвийн 60 суралцагчдад Бага тойруугийн түүхэн дурсгалт газартай танилцах явган аяллын хөтөч хийж, түүх, соёлын дурсгалыг сурталчлан таниулав.</p> <p>- 2024.04.14-нд Гайд сургалтын төвийн 56 суралцагчдад Улаанбаатар хотын төвийн хэсгийн дурсгалт газартай танилцах явган аялал зохион байгуулж, хөтөчөөр ажиллав..</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07</p> <p>Биелэлтийн хувь:100%</p>	
3.6.4	Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран хотын түүх, соёлын дурсгал, музейн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.	-	Сурталч илсан дурсгалын тоо		5	<p>Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтаран ажилласан байдал:</p> <p>2023.12.21-нд Гандан ТВ-д Монголын Тусгаар тогтнолын өдөрт зориулан Нийслэл хүрээний түүхийн талаар, 2024.01.04-нд Тэнгэр ТВ-д Түүхэн дурсгалт барилгыг буулгаж буй шалтгаан, үр дагаврын талаар, 2024.01.11-нд Itoim сайтад Түүхэн барилгуудыг буулгаж буй шалтгаан, нөхцөлийн талаар, 2024.01.23-нд Монгол Улсад орчин цагийн музей үүссэний 100 жилийн ойн баримтат нэвтрүүлэгт музейн үзмэрийн талаар, 2024.01.30-нд С1 телевизэд Циркийн барилгын асуудлаар, 2024.02.05-нд news.mn сайтад Циркийн талаар, 2024.02.27-нд Ийгл ТВ-д музейн сан хөмрөгийн тулгамдсан асуудлаар, 2024.03.26-нд Стар ТВ-д Улаанбаатар хотын ойн өдрийг яагаад 10 дугаар сарын 29-ны өдөр сонгон тэмдэглэдэг тухай тус тус ярилцлага өгөв. Тайлант хугацаанд 6 телевиз, 2 сайт, нийт 8 хэвлэл мэдээллийн байгууллагад 8 удаагийн мэдээлэл өгч хамтран ажилласан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07</p> <p>Биелэлтийн хувь:100%</p>	100 21
3.6.5	Музейн цахим хуудас, веб сайтаар дамжуулан иргэдэд хотын түүхийн талаар танин мэдэхүйн мэдлэг олгох цуврал	(-3,000) Батлагдсан төсөв дотор	Сурталч илсан мэдээллийн тоо	-	10	<p>"Улаанбаатар хотын түүх" сэдвээр дараах баримтат 10 мэдээллийг цувралаар бэлтгэв.</p> <ol style="list-style-type: none"> 1. Анхны сүлд модны наадам (1922) 2. Цанын спорт (1928) 	100 22

	мэдээллүүдийг сонирхолтой хэлбэрээр хүргэнэ.					<ul style="list-style-type: none"> 3. Булш оршуулах болов (1929) 4. Хотын ариун цэврийн товчоо (1931) 5. Замын хөдөлгөөний заавар гарав (1936) 6. Дугуйн уралдаан (1939) 7. Улсын цирк (1941) 8. Соёлын довтолгоон (1959) 9. Гоо сайхны тасаг (1962) 10. Ахуй үйлчилгээний комбинат (1970) <p>гэсэн мэдээллүүдийг “Монгол Улс Нийслэл Улаанбаатар он дарааллын бичиг” номоос бэлтгэн музейн цахим хуудас болон веб сайтаар олон нийтийн хүртээл болгосон. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь:100%</p>	
3.7	Музейн цуглуулгын каталог, шинжлэх ухааны болон олон нийтэд зориулсан ном, хэвлэл бэлтгэн нийтэлнэ. /УБХМД-4.2.7/	-	Хэвлүүлсэн бүтээлийн тоо	-	2	<p>“Улаанбаатарын мэдээ” сонины эмхтгэлийн 2-боть бэлтгэл ажил хийгдэж байна. “Социалист Улаанбаатар” хөлөгт тоглоом 300 ширхэгийг хэвлэн гаргасан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь:60%</p>	60 23
3.7.1	“Улаанбаатарын мэдээ” сонины эмхтгэлийн 2-ботийг хэвлүүлж олны хүртээл болгоно.	-	Гаргасан номын тоо		100	<p>2024.01.22-нд Улаанбаатарын мэдээ сонинд хэвлэгдсэн хотын түүхтэй холбогдох мэдээ, нийтлэлийг цахим хэлбэрт шилжүүлэх 24/01-1 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээг Пүрэвийн Жаргалантай байгуулж, энэхүү гэрээгээр тус сонинд хэвлэгдсэн 1955-1990 оны тогтоол, шийдвэрийг шивүүлж 1000 нүүр цахим баримт авахаар болов. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь:10%</p>	10 24
3.8	Соёлын биет өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд холбогдох мэдээллийг дамжуулна. /УБХМД-4.2.8/	-	Бүрдүүлсэн мэдээллийн тоо	-	5	<p>Үзмэр, эд өлгийн зүйлтэй холбоотой 2023 онд үүссэн баримт бичгүүдийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу 7 төрлийн баримтыг архивлан бүртгэл мэдээллийн санд бүрдүүлэлт хийлээ. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02 -2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	100 25

4.8.1	Музейн үзмэр, эд өлгийн зүйлтэй холбоотой 2023 оны үйл ажиллагаанд үүссэн баримт бичгийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу бүртгэл мэдээллийн санд бүрдүүлэлт хийнэ.	-	Бүрдүүлэлт хийсэн баримтын тоо	-	5	<p>Үзмэр, эд өлгийн зүйлтэй холбоотой 2023 онд үүссэн баримт бичгүүдийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу 7 төрлийн баримтыг архивлан бүртгэл мэдээллийн санд бүрдүүлэлт хийлээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Сэргээн засварлуулсан үзмэрийн тайлан 2.Бүртгэл мэдээллийн сангийн 2023 оны үйл ажиллагааний тайлан 3.Сан хөмрөгчийн ажил хүлээлцсэн тухай баримт 4.2023 онд музейд санал болгосон эд өлгийн зүйлийн холбогдолтой баримт 5.Музейд 2023 онд шинээр авсан үзмэрийн холбогдох баримт бичиг 6.Музейгээс үзмэр, эд өлгийн зүйл гаргасан тухай хөдөлгөөний акт 7.Музей дотор үзмэр, эд өлгийн зүйл хүлээлцсэн акт <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02 -2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>	100 26
3.9.1	Музейн өөрийн цахим хуудасд санхүү, үйл ажиллагаа, өргөдөл, хүний нөөцийн болон холбогдох мэдээллийг цаг тухайд нь байршуулах	-	мэдээллийн тоо	-	4	<p>-2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд бүрэн байршуулсан.</p> <p>-2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд бүрэн байршуулсан.</p> <p>-2024 оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.</p> <p>-Шилэн дансны цахим хуудсанд тухай бүр, сар бүр оруулах мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02 -2024.03.31 Биелэлтийн хувь: 100%</p>	100 27
3.9.2	Музейгээс зохион байгуулсан арга хэмжээнүүдийг байгууллагын олон нийтийн цахим сувгуудаар /инстаграм,	-	Цахим хуудаст оруулсан	-	27	<p>-Тайлант хугацаанд нийт 27 мэдээ, нийтлэл оруулж нийт 21,410 үзэгчийн хандалт авсан.</p> <p>https://ulaanbaatar.mn/government хуудсанд: Улаанбаатар хотын музейн цахим хуудсын</p>	100 28

	<p>фэйсбүүк/ дамжуулан олон нийтэд хүргэнэ.</p>		<p>мэдээллийн тоо</p>		<p>холбоосыг баннер хэлбэрээр байршуулсан. <u>www.erp.ulaanbaatar.mn</u> хуудсаар: -УБХМ-н захирлын сар шинийн мэндчилгээ, - Музейн нээлттэй өдөр, -Мал тууж саатуулах ажилд оролцов, -УБХМ харилцан хүндэтгэе аянд нэгдэв, -УБХМ-н захирлын "Монгол цэргийн баярын мэндчилгээ", -Шар усны аюулаас сэргийлье /шторк/ зэрэг 6 мэдээ, нийтлэл хүргэсэн. Музейн <u>https://www.facebook.com/UlaanbaatarCityMuseum/</u> <u>https://www.instagram.com/ulaanbaatarecitymuseum/</u> хуудсанд: -01-р сарын 31-нд Улаанбаатар хотын музейн зуны хуваарьт ажиллах постерийг бэлтгэж музейн цахим хуудсанд нийтэлсэн. - 02-р сарын 09-нд бүх нийтийн амралтын өдрүүдэд амрах хуваарийн постерийг бэлтгэж музейн цахимд хуудсанд нийтэлсэн. -02-р сарын 09-нд XVII жарны "Хилэнт эх" хэмээх модон луу жилийн сар шинийн мэндчилгээний постерийг бэлтгэн музейн цахим хуудсанд нийтэлсэн. -03-р сарын 01-нд "Музейн нээлттэй өдрүүд-2024" арга хэмжээний постерийг бэлтгэн музейн цахим хуудсанд нийтэлсэн. -03-р сарын 04-нд "Музейн нээлттэй өдрүүд 2024" арга хэмжээний хүрээнд явуулсан үйл ажиллагааны зургуудыг музейн цахим хуудсанд нийтэлсэн. -03-р сарын 04-нд Нийт үзэгчийн тоон мэдээллийг музейн цахим хуудсанд нийтэлсэн. -03-р сарын 05-нд Нийт үзэгчийн тоон мэдээллийг музейн цахим хуудсанд нийтэлсэн. -03-р сарын 06-нд Нийт үзэгчийн тоон мэдээллийг музейн цахим хуудсанд нийтэлсэн. -03-р сарын 08-нд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн мэндчилгээг</p>	
--	---	--	-----------------------	--	---	--

					<p>дэвшүүлэн Монголын эмэгтэйчүүдийн холбооны анхны тэргүүн Д.Пагмадулам /1905-1938/ зургаар постер бэлтгэн мэдээллийн хамт музейн цахим хуудсанд нийтэлсэн.</p> <p>-03-р сарын 12-нд нээлттэй ажлын байрны зарыг музейн цахим хуудсанд нийтэлсэн.</p> <p>-03-р сарын 21-нд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй "Харилцан хүндэтгэе" нэг сарын аяны постер зэргийг нийтэлсэн. Фэйсбүүк хуудсаар нийт 32 мэдээ, нийтлэлийг иргэдэд хүргэж 28,823 хандалт авсан.</p> <p>www.ubmuseum.mn хуудсанд:</p> <p>-Гамшгийн аюулын тухай зарлан тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд хамрагдлаа,</p> <p>-“Улаанбаатар хотын түүх” сэдвээр баримтат мэдээлэл бэлтгэн цувралаар хүргэж байна: #5 Замын хөдөлгөөний заавар гарав (1936),</p> <p>-“Харилцан хүндэтгэе” нэг сарын аянд Улаанбаатар хотын музей нэгдэж байна, “Улаанбаатар хотын түүх” сэдвээр баримтат мэдээлэл бэлтгэн цувралаар хүргэж байна: #4 Хотын ариун цэврийн товчоо (1931),</p> <p>-Нийслэлийн ЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг, харъяа байгууллагуудын албан хаагчид мал саатуулах ажилд оролцов зэрэг 23 мэдээ, нийтлэл нийтэлж, 1426 хандалт авсан.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%</p>		
3.9.3	Музейгээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлж, орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэн, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллана.	3,780 Нийслэлийн төсөв	Төвлөрүүлсэн орлогын хэмжээ	-	945	<p>Эхний хагас жилийн орлогын төлөвлөгөө 1,890.0 мянган төгрөг, гүйцэтгэл 1,030.5 мянган төгрөг. Тайлант хугацаанд том хүний тасалбар 200 ширхэг, оюутны тасалбар 287 ширхэг нийт 487 ширхэг тасалбар борлуулагдаж, нийт үзвэрийн орлого 1,060.5 мянган төгрөг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.</p> <p>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.03.31 Биелэлтийн хувь: 56%</p>	56 29

Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт - Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгоход чиглэсэн зорилт. /Үүнд: албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад шууд үзүүлж байгаа бүртгэл, нийгмийн халамж, нийгмийн даатгал, зөвшөөрөл/

4.1	Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх	-	шийдвэр лэсэн хоногийн тоо	-	4	Тайлант хугацаанд албан хаагчдаас нийт 12 өргөдөл ирснийг хугацаанд нь бүртгэн, шийдвэрлэж холбогдох дээд байгууллага болох "Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв"-өөр хянуулав. Өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног 14 цаг 56 минут байна. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100 1
4.2	Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах.	-	Боловсру улсан баримт бичгийн тоо	-	1	-НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.3 дахь хэсэгт заасан төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахим хэлбэрээр авч буй судалгаанд үйлчлүүлэгчдийг хамруулан үйлчилгээний тоон мэдээг НЗДТГ-ын Төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн хяналт хариуцсан ажилтан Б.Удвалын udval.b@ulaanbaatar.mn хаягт тогтмол илгээж ажилласан. -"Улаанбаатар хотын музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа"-г тогтмол авч ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 63 хүн судалгаанд хамрагдсан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 100%	100 2
4.3	Музейн үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийн дэвтрийг хариуцан хөтөлж, үр дүнг хагас бүтэн жилээр гаргаж танилцуулах	-	Боловсру улсан баримт бичгийн тоо	-	-	Тайлант хугацаанд музейн үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийн дэвтэрт нийт 10 хүний санал хүсэлтийг авсан. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07 Биелэлтийн хувь: 50%	50 3
4.4	Шилэн дансны цахим системд байршуулах санхүүгийн мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд ил тод байршуулах	-	Байршуу лсан мэдээл лийн тоо	-	39	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд бүрэн байршуулсан. -2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг шилэн дансны цахим	100 4

						хуудсанд хуулийн хугацаанд бүрэн байршуулсан. -2024 оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан. -Шилэн дансны цахим хуудсанд тухай бүр, сар бүр, улирал бүр оруулах мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан. Хугацаандаа мэдээллэсэн 73, хугацаа хоцорч мэдээлсэн 0 Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.03.31 Биелэлтийн хувь: 100%	
4.5	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудсанд ил тод байрлуулан мэдээлсэн байх.	-	Байршуулсан бичиг баримтын тоо	-	1	Байгууллагын санхүүгийн 2023 оны тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.03.31 Биелэлтийн хувь: 100%	100 5

5. Нэмэлт ажлын хүрээнд:

Д/д	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
5.1	Гадаад улсад албан томилолтоор ажиллах	Соёлын Яам	Улаанбаатар хот ЮНЕСКО-ийн "Бүтээлч хотууд"-ын сүлжээнд гар урлал, ардын урлагийн төрлөөр нэгдэн орсонтой холбогдуулан НСУГ-ын дарга тэргүүтэй, НЗДТГ-ын харьяа Улаанбаатар хотын төв номын сан, Соёлын төв өргөө, нийслэлийн дүүргүүдийн Соёлын төвийн удирдлагуудын хамт Улаанбаатар хотын музей захирал П.Даваасүрэн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд БНСУ-д албан томилолтоор ажиллаад БНСУ-н Үндсэний музей, Сөүл хотын түүхийн музейн удирдлагуудтай албан уулзалт хийгээд ирэв. Эхэлсэн, дууссан огноо: 2024.03.027-2024.06.07 Биелэлтийн хувь: 100 хувь
5.2	Албан хэрэгцээний хууль дүрмийн эмхэтгэл цэгцлэх, ашиглах	Арга зүйч	Ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглаж буй хууль дүрмийн эмхэтгэлд шинээр батлагдсан хууль дүрэм журмыг нэмж хавтаслан ашиглаж байна. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.03.31 Биелэлтийн хувь: 100 хувь
5.3	"Музейн нээлттэй хаалганы өдөр"-т оролцож ажиллах	Соёлын Яам	2024 оны 03.01-03.07-ны өдрийг дуустал орон нутаг даяар зохион байгуулагдсан "Музейн нээлттэй хаалганы өдөр"-өөр музейгээр том хүн 199, оюутан 104, гадаад хүн 4, Хөгжлийн бэрхшээлтэй хүн 11, хүүхэд 178 нийт 496 хүн үйлчлүүлсэн. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2024.06.07

			Биелэлтийн хувь: 100 хувь
5.4	"Гамшгийн үеийн дадлага, сургуулилтын бэлэн байдал, оролцоог хангах ажиллах	НЗДТГ ОБЕГ	Гамшгийн үеийн дадлага, сургуулилтын бэлэн байдал, оролцоог хангах ажлын хүрээнд 2024 оны 3 дугаар 28-ны өдрийн 16 цагт дуут дохиогоор Бөхийн өргөөний гадна Гамшгийн үед цуглах нийтийн талбайд музейн 13 албан хаагч цуглан оролцлоо. БЗД-ийн 15р хороонд bayanzurkh15khoroo@gmail.com цахим хаягаар гамшгийн үеийн дадлага сургуулилтад оролцсон тухай тайлан илгээв. Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2023.06.07 Биелэлтийн хувь: 100 хувь
5.5	Байгууллагын хог ачилтыг хариуцан ажиллах	Менежер	Музейн хог хаягдалыг улирал бүр хог тээврийн ачилт хариуцсан мэргэжилтэнд цаг тухай бүрт нь дуудлага өгч 2024 оны 02 дугаар сарын 09, 03 дугаар сарын 29-ны өдрүүдэд тус тус ачуулсан Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.02-2023.03.31 Биелэлтийн хувь: 100%

Тайлбар: 2024 оны эхний хагас жилийн байдлаар байдлаар Улаанбаатар хотын музей нь 46 арга хэмжээ хэрэгжүүлснээс 40 арга хэмжээ-100%, 1 арга хэмжээ-80%, 2 арга хэмжээ-60%, арга хэмжээ-56%, 1 арга хэмжээ-50%, 1 арга хэмжээ-10% хийгдэж нийт дүнгээр **93%-ийн** биелэлттэйгээр гүйцэтгэсэн байна.

1. Бодлогын баримт бичиг-1 арга хэмжээ-100%
 2. Хуулиар хүлээсэн-12 арга хэмжээ—12-100%
 3. Дүрмээр хүлээсэн-29 арга хэмжээ-24-100% 2-60% 1-80% 1-56% 1-10%
 4. Төрийн үйлчилгээ-5 арга хэмжээ-4-100% 1-50%
 5. Нэмэлт-5 арга хэмжээ-5-100%
- Нийт – 52 арга хэмжээ-94,53% биелэлттэй

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

БОЛОВСРУУЛСАН:
МЕНЕЖЕР



П.ДАВААСҮРЭН

Б.НАРАНГЭРЭЛ